



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Баянзүрх дүүргийн “Цэдэн-Эрдэнэ” ӨЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2026/020/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр Утас: 11315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Я.Алтанцэцэг Утас: 11315558 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: СМД аудит ХХК-ийн Гүйцэтгэх захирал: Д.Гэндэнпэлжээ Утас: 99110699 Цахим хаяг: munkhtsatsral@cmdaudit.mn Аудитор: А.Цэням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyam1202@gmail.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	1
НЭГ. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
ХОЁР. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ГҮЙЦЭТГЭЛ.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	6
3.1 Залруулсан алдаа	6
3.2 Зөвлөмж.....	6
ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	7
4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл	7
4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл	8
Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээлэл	8

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МӨАУМХ	Монголын өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбоо
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
НӨХГ	Нийслэлийн өмчийн харилцааны газар
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТББ	Төрийн бус байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
ЭМС	Эрүүл мэндийн сайд

НЭГ. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.03.13 № 589
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ
ДҮҮРГИЙН ЦЭДЭН-ЭРДЭНЭ
ӨЭМТ-ИЙН ДАРГА С.ЭНХ-ЭРДЭНЭ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, 8.4, Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д заасны дагуу Нийслэлийн Баянзүрх дүүргийн Цэдэн-Эрдэнэ Өрхийн эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Цэдэн-Эрдэнэ ӨЭМТ нь Эрүүл мэндийн даатгалын сангаас нэг иргэнд ногдох зардлын санхүүжилтээр 352.8 сая төгрөгийн, 4 төрлийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтээр 44.0 сая төгрөгийн, шүдний үзлэгийн санхүүжилтээр 1.9 сая төгрөгийн, нийт 398.7 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн ажилласан байна.

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт, эрүүл мэндийн ерөнхий газрын санхүүжилт, төлбөр тооцооны программ, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж, иргэнд чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн шинэчлэл хийсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 7 зорилтын хүрээнд 63 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 2025 оны гүйцэтгэлийн гэрээний биелэлтийг Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/47 дугаар захирамжаар 87.6 хувь,

1426050515

C:\Users\inarangua\Desktop\Бичиг хэрэг 2026\020 Word\yusan_bichig_Dugneil_2026.docx

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, худалдан авах даатгалын гэрээний биелэлтийг 97.5 хувийн хэрэгжилттэй гэж үнэлсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

ХОЁР. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1. ХӨРӨНГӨ	-	-
1.1 Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	406,499.35	830,120.70
1.1.2 Дансны авлага	21,681,446.90	5,120,361.90
1.1.3 Татвар, НДШ – ийн авлага	10,000.00	-
1.1.4 Бусад авлага	600,000.00	-
1.1.6 Бараа материал	37,361,934.39	13,817,468.17
1.1.11 Эргэлтийн хөрөнгийн дүн	60,059,880.64	19,767,950.77
1.2 Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1 Үндсэн хөрөнгө	154,046,876.01	131,411,154.43
1.2.2 Биет бус хөрөнгө	1,980,000.03	1,173,333.39
1.2.10 Эргэлтийн бус хөрөнгийн дүн	156,026,876.04	132,584,487.82
1.3 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	216,086,756.68	152,352,438.59
2. ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.1 Өр төлбөр	-	-
2.1.1 Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.1 Дансны өглөг	8,191,274.62	-
2.1.1.2 Цалингийн өглөг	330,189.00	475,801.22
2.1.1.3 Татварын өр	5,952,696.16	13,757,236.52
2.1.1.4 НДШ - ийн өглөг	7,106,009.62	13,378,745.83
2.1.1.13 Богино хугацаат өр төлбөрийн дүн	21,580,169.40	27,611,783.57
2.2 Өр төлбөрийн нийт дүн	21,580,169.40	27,611,783.57
2.3 Эздийн өмч	-	-
2.3.1 Өмч:	12,153,979.00	12,153,979.00
2.3.1.1 - төрийн	11,990,079.00	11,990,079.00
2.3.1.2 - хувийн	163,900.00	163,900.00
2.3.4 Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	212,000.00	9,812,289.78
2.3.7 Хуримтлагдсан ашиг	182,140,608.28	102,774,386.24
2.3.9 Эздийн өмчийн дүн	194,506,587.28	124,740,655.02
2.4 ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	216,086,756.68	152,352,438.59

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1. Борлуулалтын орлого (цэвэр)	-	-
2. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-	-
3. Нийт ашиг (алдагдал)	-	-
4. Санхүүжилтийн орлого	444,669,422.33	398,664,511.70
5. Хүүний орлого	53,360.87	26,728.36
8. Бусад орлого	37,223,700.00	4,643,380.95
9. Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10. Ерөнхий ба удирдлагын зардал	459,991,264.97	490,846,741.27
11. Санхүүгийн зардал	-	69,431.90
19. Орлогын татварын зардал	5,336.09	
20. Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	21,949,882.14	(87,554,823.80)
22. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	21,949,882.14	(87,554,823.80)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	(164,148.47)	(164,148.47)
2. Залруулсан үлдэгдэл	12,151,979.00	212,000.00	160,190,726.14	172,554,705.14
3. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	21,949,882.14	21,949,882.14
5. Өмчид гарсан өөрчлөлт	2,000.00	-	-	2,000.00
8. Эхний үлдэгдэл	12,153,979.00	212,000.00	182,140,608.28	194,506,587.28
9. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	8,191,274.62	-
10. Залруулсан үлдэгдэл	12,153,979.00	212,000.00	190,331,882.90	202,697,861.90
11. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(87,557,496.66)	(87,557,496.66)
15. Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	9,600,289.78	-	9,600,289.78
16. Эцсийн үлдэгдэл	12,153,979.00	9,812,289.78	102,774,386.24	124,740,655.02

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1 Мөнгөн орлогын дүн	441,596,398.43	419,484,978.01
1.1.1 Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	-	-
1.1.3 Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	489,315.00	-
1.1.5 Татаас, санхүүжилтийн орлого	441,107,083.43	419,484,978.01
1.1.6 Бусад мөнгөн орлого	-	-
1.2 Мөнгөн зарлагын дүн	441,947,083.97	419,088,085.02
1.2.1 Ажиллагчдад төлсөн	261,992,962.00	257,379,498.00
1.2.2 Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	77,749,780.65	65,698,876.33
1.2.3 Бараа материал худалдан авахад төлсөн	25,453,620.25	19,471,228.00
1.2.7 Татварын байгууллагад төлсөн	22,799,692.57	19,993,040.52
1.2.9 Бусад мөнгөн зарлага	53,951,028.50	56,545,442.17
1.3 Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(350,685.54)	396,892.99
2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1 Мөнгөн орлогын дүн	53,360.87	26,728.36
2.1.6 Хүлээн авсан хүүний орлого	53,360.87	26,728.36
2.2 Мөнгөн зарлагын дүн	-	-
2.3 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	53,360.87	26,728.36
4. Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(297,324.67)	423,621.35
5. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	703,824.02	406,499.35
6. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	406,499.35	830,120.70

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн нийт 5,881.0 мянган төгрөгийн 2 зөрчил¹ илэрч зөрчлийг давтан гаргуулахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн 5,881.0 мянган төгрөгийн алдаа, зөрчлөөс санхүүгийн тайлагналтай холбоотой 5,881.0 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

3.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 10,068.6 мянган төгрөгийн 2 алдаа² илэрснийг аудитын явцад залруулга хийлгэж, баталгаажуулсан.

- Эм боох материал дансанд 8,544.6 мянган төгрөгийн эмнэлгийн багаж хэрэгсэл бүртгэсэн;
- Тайлант онд 1 ажилтны магистрын сургалтын төлбөрт 1,524.0 мянган төгрөг төлж, авлагаар бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 “Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх” заалттай зөрчилдөж байгаа бөгөөд санхүүгийн тайлагналын “үнэлгээ ба хуваарилалт”, “ангилал”, “иж бүрэн байх”, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой асуудал:

Бараа материалын худалдан авалтын анхан шатны баримт болох цахим төлбөрийн ибаримтыг бэлтгэн нийлүүлэгч байгууллагаар шивүүлээгүй 2,631.0 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5.Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж : Бэлтгэн нийлүүлэгчдээр цахим төлбөрийн и-баримтыг бүрэн шивүүлж гүйлгээг хийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллаж, цаашид

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

² Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

ажил гүйлгээ, өглөг, авлага, төлбөр тооцоог тухай бүр хянан баталгаажуулж өр төлбөр үүсгэхгүй ажиллах зөвлөмж өгөв.

2. Тайлант онд Нийслэлийн Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвөөс 3,250.0 мянган төгрөгийн үнэ бүхий зүрхний цахилгаан бичлэгийн аппаратыг хүлээн авч орлогоор бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-д “Нягтлан бодох бүртгэлд бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал бүртгэнэ” заалтад заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үнэ төлбөргүй хүлээн авсан 3,250.0 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд бүртгэж зөрчлийг арилган, давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг НТАГ-т 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Эм боох материал дансанд 8,544.6 мянган төгрөгийн эмнэлгийн багаж хэрэгсэл бүртгэсэн	1	8,544.6			1	8,544.6	1	8,544.6		
Тайлант онд 1 ажилтны магистрын сургалтын төлбөрт 1524.0 мянган төгрөг төлж, авлагаар бүртгээгүй байна.	1	1,524.0	1	1,524.0			1	1,524.0		
Дүн	2	10,068.6	1	1,524.0	1	8,544.6	2	10,068.6		

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд Нийслэлийн БЗД-ийн Эрүүл мэндийн төвөөс 3,250.0 мянган төгрөгийн үнэ бүхий зүрхний цахилгаан бичлэгийг аппаратыг хүлээн авч орлогоор бүртгээгүй.	1	3,250.0					1	3,250.0
Бараа материалын худалдан авалтын анхан шатны баримт болох цахим төлбөрийн и-баримтыг бэлтгэн нийлүүлэгч байгууллагаар шивүүлээгүй 2,631.0 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн, байгууллага нь оны эцэст татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн 27,135.9 мянган төгрөгийн өглөгтэй гарсан байна	1	2,631.0					1	2,631.0
Дүн	2	5,881.0	-	-			2	5,881.0

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээлэл

А	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
1	ОНӨҮГ		1			1			
	НИЙТ		1			1			